

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 8, 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

“8.10. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн Төрийн албаны тухай хуулийн дагуу томилж, чөлөөлнө.”

2/16 дугаар зүйлийн 21, 22 дахь хэсэг:

“16.21. Энэ хуулийн 16.2-т заасан өрхийн эрүүл мэндийн төв нь хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл байх бөгөөд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэхээс бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

“16.22. Энэ хуулийн 16.2-т заасан нөхөрлөлийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага нь эмнэлгийн мэргэжилтэн байх бөгөөд өрхийн эрүүл мэндийн төвийн нийт ажилтны 50-аас доошгүй хувь нь тухайн нөхөрлөлийн гишүүн байна.”

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“36.1. Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн анагаах ухааны нотолгоонд суурилсан эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх үйл ажиллагаа явуулна.”

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн “15.1.5,” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“16.4. Эмнэлгийн захирлыг төлөөлөн удирдах зөвлөл таван жилийн хугацаагаар томилох бөгөөд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батламжилна.

2 дугаар зүйл. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.5 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 9.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн гарчиг, 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “, амаржих газар” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсгийн “, 61.1.4-т заасан чиг үүргийг эрүүл мэндийн даатгалын сангаас” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг